



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№006/001/20250215-006

2025 оны 2 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.17 дахь заалт, “Газар шим үйлдвэр” ХК-ийн дүрмийн 7.31.18 дахь заалт, Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Газар шим үйлдвэр” ХК болон “Эден” ХХК-ууд гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат)-д олгосугай.
2. Гэрээ, хэлцлийн хэрэгжилт, гүйцэтгэлийг сар бүр Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 02 сарын 13-ны өдөр

№ 5А/25/27

Улаанбаатар хот

Энэхүү Хамтран ажиллах гэрээ (цаашид “гэрээ” гэх)-г
Нэг талаас “Газар шим үйлдвэр” ХК (цаашид “А” тал гэх), түүнийг төлөөлж Захирал
Ц.Ганбат

Нөгөө талаас “ЕДЕН” ХХК (цаашид “Б” тал гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал
Ц.Хүрэлбаатар (хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож
байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Талууд хүнсний үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ба өөрсдийн үйлдвэрлэсэн нэрийн бүтээгдэхүүний орон нутаг дахь борлуулалтыг дэмжих, харилцан ашигтай хамтран ажиллах зорилгоор энэхүү гэрээг байгуулсан болно.
- 1.2. Энэхүү гэрээг баталгаажуулсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй байх ба талууд гэрээг дуусгавар болгох санал гаргаагүй бол тус хугацаагаар сунгагдсанд тооцно.

Хоёр. Үндсэн нөхцөл

- 2.1. Б тал нь А талын орон нутгийн борлуулалтын цэг, сүлжээ (цаашид “Сүлжээ” гэх)-нд нэгдэж өөрийн үйлдвэрийн нэрийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулна. Үүнд:
- 2.2. Б талын тухайн сарын борлуулалтын гүйцэтгэлийн 3(гурав) хувьтай тэнцэх менежментийн төлбөр төлөх ба төлбөрийг дараа сарын 05-ны өдрийн дотор А талын Голомт банк дахь 1601003176 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 2.3. Талууд бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, эрсдэлийг бууруулах зорилгоор маркетинг борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг сар, улирал, жилээр хамтран гаргах ба тухай бүр тооцоо нийлж, дүгнэлт гаргана.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1. А талын эрх, үүрэг
 - 3.1.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Б талаас шаардах эрхтэй.
 - 3.1.2. Сүлжээ дэх Б талын бүтээгдэхүүний тоо хэмжээ болон борлуулалтын өдөр тутмын мэдээг татан авах эрхтэй.
 - 3.1.3. Худалдааны төлөөлөгчийн хувьсах цалинг тооцох болон КРІ үнэлгээ гаргахдаа Б талын саналыг сарын гүйцэтгэлийг үндэслэн харгалзах үүрэгтэй.
 - 3.1.4. А тал нь Б талын нэр хүнд болон борлуулалтын үйл ажиллагааны эсрэг үйлдэл хийхийг хориглоно.
- 3.2. Б талын эрх, үүрэг
 - 3.2.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг А талаас шаардах эрхтэй.
 - 3.2.2. Худалдааны төлөөлөгчийн хувьсах цалин болон КРІ үнэлгээнд санал өгөх, танилцах эрхтэй.
 - 3.2.3. Борлуулалтын төлөвлөгөө болон тайлан гаргахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт бичгийг А талын шаардсан тухай бүр үнэн зөв, саадгүй гарган өгөх үүрэгтэй.
 - 3.2.4. Гэрээнд хамаарч буй А талын орон нутгийн худалдааны төлөөлөгч нарт Б тал борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой заавар чиглүүлэг, сургалт өгөх, тайлан мэдээ авах, борлуулалт дэмжих зэрэг нэмэлт ажил хийлгэх эрхтэй.

- 3.2.5. Гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэгтэй ба тухайн төлбөрийг гэрээний 2.3-д заасныг удирдлага болгон хоорондын тооцооноос суутгаж шийднэ.
- 3.3. Талууд гэрээний хэрэгжилт болон борлуулалтын үйл ажиллагаанд дангаар болон хамтран хяналт тавих, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах үүрэгтэй.
- 3.4. Хууль болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас нөгөө тал, гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. **Нэмэлт өөрчлөлт:** Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ дуусгавар болгох асуудлыг нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд зөвхөн бичгээр харилцан тохиролцож оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.2. **Нууцлал:** Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор солилцсон мэдээлэл, баримт бичгийн нууцлал, борлуулалтын ноу хауг хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд нөгөө тал бичгээр зөвшөөрөл олгосон эсхүл хууль тогтоомжид заасны дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй нийтэд мэдээлэхгүй, энэхүү гэрээнээс өөр зорилгоор ашиглахгүй.
- 4.3. **Эрсдэл:** Б тал нь өөрийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, худалдан борлуулалттай холбоотой гуравдагч этгээдийн шаардах эрх, хүлээх үүрэг, хариуцлагаас А талыг ангид байлгаж, аливаа эрсдэлийг дангаар хүлээнэ.
- 4.4. **Маргаан шийдвэрлэх:** Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэх ба шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.5. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Энэхүү Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.


А талыг төлөөлж
Гүйцэтгэх захирал Ц.Ганбат

Хаяг: БГД, 20-р хороо,
Үйлдвэрийн баруун бүс,

Утас: 99112827

Борлуулалтын албаны дарга

А.Алтансүх

И-мэйл хаяг: Altansukh.a@gazarshim.mn

Утас:

Санхүүгийн албаны дарга

М.Хурцбилэг

И-мэйл хаяг: khurtsbileg@gazarshim.mn

Утас: 90261414

Гэрээг байгуулсан:


EDEN LLC
Б талыг төлөөлж

Гүйцэтгэх захирал Ц.Хүрэлбаатар

Хаяг: БГД, 20-р хороо,
Үйлдвэрийн баруун бүс,

Утас: 75059999

Борлуулалтын албаны дарга

Б.Нямбат

И-мэйл хаяг: Nyambat@eden.mn

Утас: 99625577

Нягтлан бодогч

Г.Даваасүрэн

И-мэйл хаяг: Finance@eden.mn

Утас: 88809370